# ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН НИЙГМИЙН ДААТГАЛ БОЛОН ТЭТГЭВРИЙН ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦОО, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВТ ЭЗЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭ

(Мэдээлэл лавлагаа)

*Р.Хатанбаатар, Д. Живгаагүнсэл,*
*Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл*

## АГУУЛГА

Удиртгал

Дэлхийн улс орнуудын нийгмийн даатгал болон тэтгэврийн хуримтлалын тогтолцоо, нийгмийн хамгааллын зардлын төсөвт эзлэх хувь хэмжээ

1. Дэлхийн улс орнуудын нийгмийн даатгал болон тэтгэврийн хуримтлалын тогтолцоо
2. Гадаадын улс орнуудын тэтгэврийн зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ
3. Монгол Улсын нийгмийн хамгааллын зардлын төсөвт эзлэх хувь хэмжээ, өсөлтийн шалтгаан

Ашигласан материал

Хавсралтууд

Хавсралт 1. Зүүн Ази, Номхон далайн орнуудын тулгууруудын загварчлал
Хавсралт 2. Европ болон Төв Азийн орнуудын тулгууруудын загварчлал
Хавсралт 3. Латин Америк, Карибын орнуудын тулгууруудын загварчлал
Хавсралт 4. Дундад Ази болон Өмнөд Африкийн орнуудын тулгууруудын загварчлал
Хавсралт 5. Өмнөд Азийн орнуудын тулгууруудын загварчлал
Хавсралт 6. Сахарын Африкийн бүс нутгийн орнуудын тулгууруудын загварчлал
Хавсралт 7. Сахарын Африкийн бүс нутгийн орнуудын тулгууруудын загварчлал
Хавсралт 8. Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Холбооны Байгууллагуудын орнуудын тулгууруудын загварчлал

## УДИРТГАЛ

### *Судалгааны зорилго*

Энэхүү судалгаагаар дэлхийн улс орнуудын нийгмийн хамгаалал, тэтгэврийн хуримтлалын тогтолцоог харьцуулан судлах, дэлхийн улс орнууд болон Монгол Улсын нийгмийн халамжийн зардлын төсөвт эзлэх хувь хэмжээг гаргахыг зорьсон болно.

### *Судалгааны дүгнэлт*

Дэлхийн олон улс орнуудад 1990-ээд оноос эхлэн хүн амын хөгшрөлтийн явц түргэсэж, нэг ажиллагчид ногдох тэтгэвэр авагчдын тоо хурдацтай өсөх хандлага бий болсон байна.

Нэг. Хүн амын хөгшрөлт хурдацтай нэмэгдэж байгаа Европын болон өмнөд Америкийн олон орнуудад тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг тууштай хэрэгжүүлсэн байна. Зүүн европ, Скандинавын орнууд, Польш, Казахстанд гурван түвшинт тэтгэврийн тогтолцоонд, өмнөд Америкийн Чили, Аргентин, Перу, Колумб зэрэг улсад цэвэр хуримтлалын тогтолцоонд шилжих алхмуудыг амжилттай хэрэгжүүлж байна.

Хоёр. Дэлхийн улс орнуудын тэтгэврийн зардлын түвшнийг дараах ангиллаар ДНБ-д эзлэх хувиар авч үзвэл:

- Өмнөд Ази (South Asia) - 0.5%,
- Африкийн орнууд (Sub-Saharan Africa) - 1%,
- Зүүн Ази, Номхон далайн орнууд - 1.8%,
- Латин Америк, Карибийн орнууд - 2.5%,
- Дундад Ази, Өмнөд Африк - 3%,
- Орлого өндөр ЭЗХАХБ-ын орнууд (High income: OECD) - 7.3%,
- Европ болон Төв Азийн орнууд (Europe & Central Asia region) - 8.3% байна.

Гурав. Монгол Улсын нийгэм хамгааллын зардлын төсөвт эзлэх хувь, хэмжээ 1995, 2000, 2005, 2010, 2012 онуудад тасралтгүй бөгөөд хурдацтай өссөн байдалтай байна. Энэ нь хүн амын өсөлт, нийгмийн халамжийн төрөл, зүйл нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж болохоор байна.

## ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН НИЙГМИЙН ДААТГАЛ БОЛОН ТЭТГЭВРИЙН ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦОО, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВТ ЭЗЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭ

### *Нэг. Дэлхийн улс орнуудын нийгмийн даатгал, тэтгэврийн хуримтлалын тогтолцоо*[105]

Тэтгэврийн тогтолцоог авч үзэхдээ хэрхэн даатгалын хуримтлалаа бүрэлдүүлэх, тэтгэмж олгох үндсэн байгууллага, бүтэц ба дүрэм журмын хүрээ зэргийг тодорхойлох явдал юм.

Дэлхийн банкнаас үндэсний тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд албан журмын хуримтлалын тогтолцооны элементийг оруулахыг санал болгосон байна.

*Албан журмын хуримтлалын тэтгэврийн тогтолцоо*

Дэлхийн нийтэд албан журмын хуримтлалын тэтгэврийн маш олон янзын тогтолцоо байдаг. Тэдгээр тогтолцоог *(тэтгэврийг хэрхэн тооцоолон бодож байна, тэтгэврийг хэрхэн санхүүжүүлж байна, тогтолцооны менежментийг хэн хариуцаж байна гэхчлэн)* харилцан адилгүй өөр өөр шалгууруар ангилдаг байна.

Мөн улс орнуудыг тэтгэврийн хэв загваруудаар нь *(тэтгэврийн хэчнээн тулгууртай байна вэ гэдгээр нь)* эсвэл тэдэнд нэгдмэл тэтгэврийн тогтолцоо байна уу, үгүй юү гэдгээр нь ангилан үзэж болно.

Дэлхийн 176 улс орны албан журмын тэтгэврийн схемийг ажиглан үзвээс: тэтгэврийн загварчлалын хувьд 66% нь DB (defined benefit)-тодорхой тогтоосон тэтгэвэртэй буюу хуваарилалтын тогтолцоотой, 15% нь DC-(defined contribution) тодорхой шимтгэлийн буюу хуримтлалын тогтолцоотой, 10% нь PF- (provident funds) хяналтын сантай, 6% нь Zero pillar -тэг тулгууртай, 3% нь NDC-нэрийн дансны тогтолцоотой байна.

Улмаар менежментийн төрөл зүйлийн хувьд 82% нь улс нь хариуцдаг, 18% нь хувийн салбар хариуцдаг байна.

Дэлхийн бүх орны бараг тэн хагаст нь төрийн албаныхан (ба бусад тусгай бүлгүүдэд)-нд тусгай тэтгэврийн схемтэй байдаг. Энэ мэт тусгай схемийг улсын схемтэй нэгтгэх хандлага нэлээд өсөж байна. Одоогоор *Албан журмын хуримтлалын тэтгэврийн тогтолцоо*гоор дэлхийн 20-оос дээш улс оронд тэтгэврийн тогтолцоогоо хараахан бүрэн дүүрэн биш ч

[105]http://www-wds.worldbank.org/ - International Patterns of Pension Provision II, “Social protection&labor“ 2012.

гэсэн ийнхүү нэгтгээд байгаа юм. Гэсэн хэдий ч, олон улс оронд өөрсдийн тэтгэврийн тусгай тогтолцоог нийтийн тогтолцоотойгоо нэгтгэх явц эрчимжиж байна. Бага буурай болон орлого багатай улс орнуудын тухайд ийнхүү нэгтгэх явц хурц шүүмжлэлтэй тулгарч байгаа ч алс хэтдээ улс үндэстний нэгэн схем тогтолцоо нь тэгш байдал, үр дүнтэй засаглах ба хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлын үүднээс зөв зүйтэй юм гэж үзэх хандлагатай байна.

*Тэтгэврийн тогтолцооны төрөл зүйл*

Тэтгэврийн ерөнхий тогтолцоо нь дараах хэд хэдэн үндсэн асуудалтай холбоотой байна. Тухайлбал,

- Тэтгэврийн үндсэн хэлбэр - тухайн тогтолцоо нь хуваарилалтын (DB), хуримтлалын (DC) эсвэл нэрийн данс (NDC)-ны тогтолцоо гэх зэргийн аль нэг байхаас
- Тэтгэврийн санхүүжилт - энэ нь тухайн хүн хэрхэн даатгалаа төлж ирснээс хамааран эсвэл бүрэн эсвэл хэсэгчлэн, аль эсвэл урьдчилан бүрэн санхүүжиж байна уу гэдгээс
- Тэтгэврийн тогтолцооны менежмент - энэ нь улс хариуцаж байна уу аль эсвэл хувийн байгууллага хариуцаж байна уу гэх зэргээс шалтгаалан тодорхойлогдоно.

Тэтгэврийн тогтолцоог тодорхойлогч эдгээр гурван шинж чанарын хооронд маш нягт уялдаа холбоо байдаг.

Тэтгэврийн тогтолцоог тэтгэврийн олон тулгуурт хүрээтэй хамаатуулан Дэлхийн банкнаас 2005 онд тэтгэврийн тогтолцооны бүрдлийг 5 тулгуурт ялган ангилах саналыг дэвшүүлсэн байдаг. Тэдгээр нь:

- даатгал төлдөггүй «тэг тулгуур»,
- албан журмын орлогод суурилсан «нэгдүгээр тулгуур»,
- албан журмын хуримтлалд суурилсан «хоёрдугаар тулгуур»,
- нэмэлт сайн дурын «гуравдугаар тулгуур»,
- санхүүгийн бус «дөрөвдүгээр тулгуур» *(үүнд албан бус дэмжлэгүүд, бусад эрүүл мэнд ба орон байр гэх зэрэг албан ёсны хөтөлбөрүүдэд хамруулах, өөр бусад гэр орноо эзэмших, моргежийн зээлийг цуцлах гэх мэт хувь хүний санхүүгийн болон санхүүгийн бус боломжууд багтана)* зэрэг болно.

Дөрөв ба тавдугаар тулгуурууд нь сайн дурын үндэслэлтэй учраас ихэнх албан журмын нийгмийн хамгааллын системд багтдаггүй. Тийм ч учраас, энд зөвхөн бусад гурван тулгуурыг нь тодотгон үзэв. Тухайлбал,

***Тэг тулгуур:*** Энэ нь даатгал төлдөггүй бөгөөд тэтгэврийг даатгал төлөлтийн түүх тэмдэглэлгүйгээр олгодог. Эдгээр нь ахмад үеийнхэнд мөнгөн тэтгэмж олгодог ба, заримдаа үүнийг «*нийгмийн тэтгэвэр*" гэж нэрлэдэг. Энэ нь нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс ахмад настнуудад амьдралын баталгаажих түвшний мөнгийг олгодог схем юм. Тиймээс улс орон даяар хэрэгжүүлэх бөгөөд гол төлөв улсын ерөнхий орлогоос санхүүжүүлдэг.

Энэ схемд хоёр үндсэн төрөл зүйл бий. Нэг нь гагцхүү амьжиргааны түвшин доогуур ахмад настнуудад тэтгэмж олгох хөтөлбөр, нөгөө нь улс даяар тухайлан заасан наснаас дээш настай, тухайн улсын тодорхой иргэдэд тэтгэмж олгох юм. Ийм хөтөлбөргүй ихэнх улс орнуудад ахмад настнууддаа нийгмийн халамжийн маш өргөн хөтөлбөрүүдээрээ дамжуулан тэтгэлэг олгодог байна.

***Нэгдүгээр тулгуур:*** Эдгээр нь хамрагдах гишүүдийнхээ орлогоос шимтгэл авдаг албан журмын тогтолцоо тул гол төлөв орлогод суурилсан схемийн шинж чанартай байдаг. Нэгдүгээр тулгуурт 3 үндсэн төрлийн схем бий.

5. *DB (defined benefit)* - Эдгээрийн ихэнх нь тухайн хүнийг тэтгэврийн насанд хүрмэгц орлого ба төлсөн шимтгэл даатгалын түүхийг шууд тооцон гаргах томьёолол бүхий цэвэр тодорхой тогтоосон тэтгэврийн схемүүд юм. Цөөн тооны улс орнуудад дээрх төрөл хэлбэрийн тэтгэврийн схемийн арай өөр хувилбарыг сонгон хэрэгжүүлдэг болжээ. Энэ нь хамрагдаж буй хүмүүс нь тодорхой цаг үеийн туршид эсвэл шимтгэл хандивын түвшинд заасан хэмжээний оноог цуглуулдаг, өөрөөр хэлбэл, онооны системд суурилсан схем юм. Эдгээр оноо нь цаанаа үнэлгээтэй байх тул тэтгэврийн насанд хүрэх үед тухайн нэг хүний цуглуулсан оноо ба тэдгээрийн үнэлгээний тооцоо нь тэтгэврийн үндэслэл болж байдаг байна.
6. *PF (provident funds)* - Хяналтын сан нь улсаас төвлөрсөн менежменттэй, тодорхой тогтоосон шимтгэл даатгалын схем мөн бөгөөд улс хариуцдаг ба зах зээлийн бус хэлбэрийн хэрэглээ, улсаас тогтоосон хүү шимтгэлтэй байдгаараа энэхүү категоричлал буюу ангилалд ордог.
7. *NDC- (Notional Defined-Contribution)* - 1990-ээд оноос цөөн тооны орнуудад нэгдүгээр тулгуурын гурав дахь хувилбар бий болсон байдаг нь нэрийн дансны схем юм. Жишээ нь Монгол, Итали улсууд энэ хувилбарт ордог. Тэдгээр орнуудад хувь хүний шимтгэл даатгалын дансны тэмдэглэлийг баримтлах ба, тэр нь «тодорхой хувийн хүү» бодогдох индекстэй байдаг байна. Ингээд тэтгэвэрт гарах үед нь энэхүү нэрийн дансыг урьдчилан тооцож гаргасан томьёогоор бодож хөрвүүлэн тэтгэврийг тогтоодог.

Ихэнх нэгдүгээр тулгуурын тогтолцоо нь «**pay as you go**” буюу хуваарилалтын зарчмаар, тодорхой хэлбэл одоогийн ажил эрхэлж буй хүмүүс тухайн үеийнхээ тэтгэврийн насныхны тэтгэмжийг төлж явдаг схем юм. Хамгийн их хэмжээний тэтгэвэр ихэвчлэн нэгдүгээр тулгуурын тэтгэврийн тогтолцооны хэсэг болж явдаг. Хамгийн бага хэмжээний тэтгэвэр нь тэг тулгуураас хоёр үндсэн зүйлээрээ ялгаатай байдаг. Нэгдүгээрт, энэхүү нэгдүгээр тулгуурын тэтгэвэрт хамрагдахын тулд хамгийн багадаа тодорхой тооны жил шимтгэл даатгал төлсөн байхыг шаарддаг. Хоёрдугаарт, тодорхой заасан тэтгэврийн насанд хүрсэн хүн бүрд энэхүү нэгдүгээр тулгуурын тэтгэвэрт хамрагдах боломж байдаг. Тиймээс үүнийг бас өөрөөр “иргэний тэтгэвэр” гэж нэрлэдэг.

**Хоёрдугаар тулгуур:** Эдгээр албан журмаар төлдөг хувь хүний данс тооцооны менежментийг хувийн байгууллага хариуцдаг байна. Эдгээр нь бусад сайн дурын хуримтлалын тогтолцооноос ихээхэн ялгаатай. Эдгээр тогтолцоог тусгай тэтгэврийн байгууллага тусгайлан гаргасан хууль, дүрэм журмын дагуу тусгайлан удирдаж хянан зохицуулж явдгаараа онцлог юм. Энэ тулгуурт DB- хуваарилалтын болон DC-хуримтлалын схемууд ордог. Одоогоор дэлхийн 32 улс оронд ийм хоёрдугаар тулгуурын тогтолцоо байдаг боловч 2008-2009 оны хямралаас шалтгаалан хэд хэдэн орон нь энэ тогтолцооноос бүрэн болон бүрэн бус байдлаар татгалзаад байна. Ийм тогтолцоотой орнуудын ихэнх нь Латин Америк, Зүүн Европ, Төв Азид байдаг. (Хүснэгт 1-ээс дэлгэрэнгүй үзнэ үү.)

**Хүснэгт 1. Тэтгэврийн тогтолцооны загварчлал (бүсчлэлээр)**

| *Бүс нутаг* | *Улс орны тоо* | *Тулгуурын загварчлал* | | | *Үндэстний схем ба төрийн албан хаагчдын схем* | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | *Тэг тулгуур* | *1 тулгуур* | *2 тулгуур* | *Ангид тусдаа* | *Нэгдмэл* | *Бүрэн бус нэгдмэл* |
| Зүүн Ази ба Номхон далайн бүс | 28 | 11 | 17 | 1 | 9 | 7 | 2 |
| Европ ба Төв Ази | 30 | 17 | 30 | 14 | 1 | 29 | 0 |
| Латин Америк ба Карибын бүс | 37 | 19 | 29 | 10 | 3 | 22 | 5 |
| Дундад Ази ба Хойд Африк | 20 | 2 | 18 | 1 | 7 | 8 | 3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Өмнөд Ази | 8 | 4 | 4 | 1 | 7 | 8 | 3 |
| Сахарын Африк | 46 | 8 | 33 | 2 | 24 | 11 | 1 |
| Өндөр орлоготой орнууд | 24 | 20 | 20 | 3 | 10 | 11 | 2 |
| НИЙТ | **193** | **81** | **151** | **32** | **60** | **89** | **13** |

**Төрийн албан хаагчдын ба бусад тусгай схемүүд:**

Дэлхийн банкинд мэдээлэл нь буй улс орнуудын бараг тэн хагас нь төрийн албан хаагчдын тусгай тэтгэврийн схемтэй байдаг. Гэхдээ олон улс орон одоо тусгаар тэтгэврийн схемүүдээ нэгтгэж байна. Төрийн албаны ба бусад улс нийтийн салбарын ажилтан, албан хаагчид- цэрэг арми, боловсролын салбарынхан, улсын эзэмшлийн аж ахуйн нэгжүүд- зэрэг нь үндсэндээ Засгийн газрын санхүүжилт бүхий тэтгэврийн схемд хамрагдах нэгдүгээр бүлгийн ажилтан, албан хаагчид юм. Ингээд албан журмын тэтгэврийн тогтолцоо нь хувийн секторынхныг хамруулан тэлэх үед төрийн албан хаагчид энэ мэт улсын шинэ схемд хамрагддаггүй байна. Учир нь: 1) тэд аль хэдийнээ хамрагдсан тогтолцоотой, 2) тэдгээр шинэ схемийн бүтцэд засгийн газрын хүний нөөцийн менежментийн зорилтуудыг тэр бүр багтааж чаддаггүй, 3) төрийн албан хаагчид нийтийн схемд хамрагдан орохоос татгалздаг зэрэг учир шалтгаанууд бий.

Дэлхийн улс орнуудын тэтгэврийн тогтолцооны загварчлалыг бүс бүрээр авч үзвэл, **Зүүн Ази, номхон далайн бүсийн** 24 орнуудын 50 орчим хувь нь албан ёсны нэгдсэн тэтгэврийн схемтэй. Харин 7 улс нь одоо ч төрийн алба нийтийн тэтгэврийн тогтолцоо нь нэгдмэл бус тусгаар, 10 улс нь төрийн албанаас бусад мэргэжлийн бүлгүүдэд зориулсан тусгай схемтэй. Энэ бүс нутагт тэтгэвэрт гардаг дундаж нас 58, эрт гардаг нь 55, хамгийн бага ажилласан жил нь 14 байдаг байна. *(Хавсралт 1.)*

**Европ, Төв Азийн** 30 орноос ОХУ болон Латви улс NDC- нэрийн дансны тогтолцоотой бөгөөд холимог буюу нэмэлтээр хуримтлалын тогтолцоог хэрэглэдэг, Косово улс ямар нэгэн схем хэрэглэдэггүй бол бусад 27 улс нь нэгдүгээр тулгуурын DB- хуваарилалтын тогтолцоотой байна. *(Хавсралт 2.)*

**Латин, Америк, Карибын бүс** нутгийн 39 орны 2 нь буюу Чили, Доминикан Улсууд DC- хуримтлалын тогтолцоотой бол бусад 36 улс нь DB- хуваарилалтын тогтолцоотой байх бөгөөд нэмэлт хуримтлалын тогтолцоог давхар сонголтын хэлбэрээр авч явдаг байна. *(Хавсралт 3.)*

**Дундад ази, Хойд Африкийн** 20 орны 90 хувь буюу 17 нь DB- хуваарилалтын тогтолцоотой, харин бусад 3 улс нь ямар нэгэн схем хэрэглэдэггүй байна. *(Хавсралт 4.)*

**Өмнөд Азийн** 8 орны 4 нь ямар нэгэн систем хэрэглэдэггүй бол 2 нь DB- хуваарилалтын, 2 нь PF- хяналтын сангийн тогтолцоотой байна. *(Хавсралт 5.)*

**Сахарын Африкийн бүс нутгийн** 46 орны 11 улс ямар нэгэн тогтолцоогүй байдаг бол бусад 55 улсын 2 нь буюу Кени, Гамби улсууд PF- хяналтын сангийн тогтолцоотой бол 53 улс нь хуваарилалтын тогтолцоотой байна. *(Хавсралт 6.*)

Харин **өндөр орлоготой** орнуудын тухайд 24 орноос Итали, Швед, Австрали улсууд хуримтлалын болон нэрийн дансны тогтолцоотой бол Нидерланд, Исланд, Ирланд, Дани, Шинэ Зеланд зэрэг улсуудаас бусад 16 улс буюу нийт улсуудын 66 хувь нь DB- хуваарилалтын тогтолцоотой байна. *(Хавсралт 7.)*

**Нийгмийн даатгалын хуримтлалын тогтолцоотой улс орнуудын жагсаалт**

*Хуримтлалын тогтолцоотой орнууд:*

1. *Хонгконг*
2. *Чили*
3. *Доминикан*
4. *Малдив*
5. *Нигери*
6. *Австрали*

*Нэрийн дансны тогтолцоотой орнууд:*

1. *Монгол*
2. *Итали*

*Хуримтлалын, хуваарилалтын болон нэрийн дансны тогтолцооны 2-ыг нь хамт хэрэглэдэг холимог (нэмэлт схем) тогтолцоотой улс орнууд:*

1. *Азербайжан*
2. *Киргиз*
3. *Польш*
4. *Болгар*
5. *Хорват*
6. *Эстони*
7. *Унгар*
8. *Казахстан*
9. *Косово*
10. *Латви*
11. *Литва*
12. *Македон*
13. *Румынь*
14. *ОХУ*
15. *Словак*
16. *Тажикстан*
17. *Колумб*
18. *Косто-Рика*
19. *Эл-Салвадор*
20. *Мексико*
21. *Перу*
22. *Уругвай*
23. *Энэтхэг*
24. *Ганн*
25. *Норвег*
26. *Швед*
27. *Швейцар*

*Хуваарилалтын тогтолцоотой улс орнууд:*

*Бусад 160 улс орон хуваарилалтын тогтолцоотой байна.*

Дээрх улс орнуудын тэтгэврийн тогтолцоо, схемийг харахад нийт улс орнуудын 3.1% нь хуримтлалын, 1.03% нь нэрийн дансны, 82.9% нь хуваарилалтын, 13.9% нь холимог тогтолцоотой буюу 2 тогтолцоог хамтад хэрэглэдэг байна.

***Хоёр. Дэлхийн улс орнуудын ДНБ-д тэтгэврийн зардлын эзлэх хувь***

Судалгааны сэдвийн хүрээнд дэлхийн улс орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүнд тэтгэврийн зардлын эзлэх хувь хэмжээг дэлхийн банкны 2012 онд хийгдсэн судалгааны мэдээллээс бэлтгэв. Судалгаанд дэлхийн 185 орныг бүсчилсэн байдлаар авч үзэж ДНБ-д тэтгэврийн зардлын эзлэх дундаж хэмжээг гаргасан байна. *(*Зураг 1-ээс үзнэ үү*.)*

**Зураг 1 . Дэлхийн улс орнуудын ДНБ-д тэтгэврийн зардлын эзлэх дундаж хэмжээ, хувиар, бүс нутгаар**




*Source: World Bank Pens*

Дэлхийн улс орнуудын тэтгэврийн зардлын түвшинг ДНБ-д эзлэх хувиар авч үзвэл:

- *Өмнөд Ази (South Asia)-0.5%,*
- *Сахарын Африкийн бүс нутгийн орнууд (Sub-Saharan Africa)-1%,*
- *Зүүн Ази, Номхон далайн орнууд (Pension spending, selected countries East Asia&Pacific region)-1.8%,*
- *Латин Америк, Карибийн орнууд (Pension spending, Latin America& the Caribian region)-2.5%,*
- *Дундад Ази, Өмнөд Африк (Pension spending, Middle East& North Africa region)-3%,*
- *Европ болон Төв Азийн орнууд (Europe&Central Asia region)-8.3%,*
- *Орлого өндөр ЭЗХАХБ-ын орнууд (High income: OECD)-7.3% байна.*

***Зүүн Ази, Номхон далайн орнуудын тэтгэврийн зардал ДНБ-д эзлэх хувиар*** *(Pension spending, selected countries East Asia&Pacific region)*

Бүс нутгийн нийт 24 улс орны тэтгэврийн зардал ДНБ-ний 6-аас дээш хувийг Монгол, дараа нь Маршаллын арлууд, 2 орчим хувь нь Вьетнам, Хятад, бусад бүс нутгууд ДНБ-ий 2 хүрэхгүй хувийг зарцуулдаг. *(Хүснэгт 1.)*

**Хүснэгт 1.**

| *№* | *Орон* | *Тэтгэврийн зардал* | |
|---|---|---|---|
| | | *Огноо* | *ДНБ (GDP%)* |
| 1 | Brunei Darussalam | - | - |
| 2 | Cambodia | 2005 | 0.6 |
| 3 | China | 2006 | 2.5 |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Fiji | 2005 | 0.5 |
| 5 | Hong Kong SAR, China | 2006 | 1.6 |
| 6 | Indonesia | 2010 | 1.0 |
| 7 | Kiribati | - | - |
| 8 | Korea, Rep. | 2005 | 1.6 |
| 9 | Lao PDR | 2005 | 0.2 |
| 10 | Malaysia | 2004 | 0.3 |
| 11 | Marshall Islands | 2005 | 7.4 |
| 12 | Micronesia, Fed. Sts. | - | - |
| 13 | Mongolia | 2009 | 4.9 |
| 14 | Palau | - | - |
| 15 | Papua New Guinea | 2005 | 0.2 |
| 16 | Philippines | 2003 | 1.5 |
| 17 | Samoa | - | - |
| 18 | Singapore | - | - |
| 19 | Solomon Islands | - | - |
| 20 | Thailand | 2006 | 0.8 |
| 21 | Timor-Leste | - | - |
| 22 | Tonga | 2005 | 0.9 |
| 23 | Vanuatu | 2005 | 0.3 |
| 24 | Vietnam | 2004 | 2.5 |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

***Европ болон Төв Азийн тэтгэврийн зардал ДНБ-д эзлэх хувиар*** *(Pension spending, Europe &Central Asia region)*

2010 оны байдлаар бүс нутгийн 31 орныг хамруулсан судалгаанд Украин улсын тэтгэврийн зардал ДНБ-ий 17, Серби ба Словен, Беларус, Босни, Хорват, Унгар, Польш 10 гаруй хувийг эзэлдэг байна. *(*Хүснэгт 2*.)*

**Хүснэгт 2.**

| *№* | *Орон* | *Тэтгэврийн зардал* | |
|---|---|---|---|
| | | *Огноо* | *ДНБ (GDP%)* |
| 1 | Albania | 2009 | 6.1 |
| 2 | Armenia | 2006 | 3.2 |
| 3 | Azerbaijan | 2007 | 3.8 |
| 4 | Belarus | 2008 | 10.2 |
| 5 | Bosnia and Herzegovina | 2009 | 9.4 |
| 6 | Bosnia Republika Srpska | 2009 | 10.3 |
| 7 | Bulgaria | 2008 | 8.5 |
| 8 | Croatia | 2009 | 10.3 |
| 9 | Czech Republic | 2007 | 8.5 |
| 10 | Estonia | 2007 | 10.9 |
| 11 | Georgia | 2004 | 3 |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Hungary | 2008 | 10.5 |
| 13 | Kazakhstan | 2009 | 3.2 |
| 14 | Kosovo | 2009 | 2.7 |
| 15 | Kyrgyz Republic | 2010 | 2.7 |
| 16 | Latvia | 2009 | 8.5 |
| 17 | Lithuania | 2009 | 8.9 |
| 18 | Macedonia, FYR | 2008 | 9.4 |
| 19 | Moldova | 2009 | 9.1 |
| 20 | Montenegro | 2007 | 9.6 |
| 21 | Poland | 2009 | 10 |
| 22 | Romania | 2009 | 8.3 |
| 23 | Russian Federation | 2007 | 4.7 |
| 24 | Serbia | 2010 | 14 |
| 25 | Slovak Republic | 2007 | 9.3 |
| 26 | Slovenia | 2007 | 12.7 |
| 27 | Tajikistan | - | - |
| 28 | Turkey | 2008 | 6.2 |
| 29 | Turkmenistan | - | - |
| 30 | Ukraine | 2010 | 17.8 |
| 31 | Uzbekistan | 2005 | 6.5 |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

***Латин Америк, Карибын орнууд тэтгэврийн зардал ДНБ-д эзлэх хувиар*** *(Pension spending, Latin America& the Caribian region)*

Тус бүс нутгийн нийт 32 орноос Бразил, Уругвай Аргентин ДНБ-ний 6,2-8,8 хувь, Чили, Венесуэл, Колумб 3,5-5 дундаж , бүс нутгийн улс орнуудын үлдсэн хэсэг нь ДНБ-ний 3-аас бага хувийг зарцуулдаг байна. *(*Хүснэгт 3-аас үзнэ үү*.)*

**Хүснэгт 3.**

| № | Орон | Тэтгэврийн зардал | |
|---|---|---|---|
| | | Огноо | ДНБ *(GDP%)* |
| 1 | Antigua and Barbuda | - | - |
| 2 | Argentina | 2010 | 7.4 |
| 3 | Barbados | - | - |
| 4 | Belize | 2009 | 0.9 |
| 5 | Bolivia | 2009 | 1.5 |
| 6 | Brazil | 2010 | 6.2 |
| 7 | Chile | 2009 | 5.0 |
| 8 | Colombia | 2010 | 3.5 |
| 9 | Costa Rica | 2009 | 2.8 |
| 10 | Cuba | - | - |
| 11 | Dominica | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Dominican Republic | 2009 | 0.7 |
| 13 | Ecuador | 2010 | 1.8 |
| 14 | El Salvador | 2010 | 1.7 |
| 15 | Grenada | - | - |
| 16 | Guyana | 2010 | 0.1 |
| 17 | Haiti | - | - |
| 18 | Honduras | 2010 | 0.1 |
| 19 | Jamaica | 2004 | 0.7 |
| 20 | Mexico | 2007 | 1.4 |
| 21 | Nicaragua | - | - |
| 22 | Panama | - | - |
| 23 | Paraguay | 2001 | 1.2 |
| 24 | Peru | 2010 | 2.5 |
| 25 | St. Kitts and Nevis | 2005 | 1.3 |
| 26 | St. Lucia | 2004 | 1.2 |
| 27 | St. Vincent and the Grenadines | 2003 | 1.1 |
| 28 | Suriname | - | - |
| 29 | Trinidad and Tobago | 2010 | 2.8 |
| 30 | Uruguay | 2010 | 8.8 |
| 31 | Venezuela, RB | 2010 | 5.0 |
| 32 | Guatemala | 2009 | 1.2 |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

***Дундад Ази болон Өмнөд Африкийн орнуудын тэтгэврийн зардал ДНБ-д эзлэх хувиар*** *(Pension spending, Middle East& North Africa region)*

Нийт 20 орноос Мальт 9 орчим хувь, Тунис, Египет, Баруун эргийн газрын зурвас дундаж, Алжир, Ирак 3-аас дээш хувийг, бүс нутгийн улс орны үлдсэн хэсэг нь 3 аас доош хувийг зарцуулдаг. *(*Хүснэгт 4-өөс үзнэ үү.*)*

**Хүснэгт 4.**

| № | Орон | Тэтгэврийн зардал | |
|---|---|---|---|
| | | Огноо | ДНБ-д эзлэх хувь *(GDP%)* |
| 1 | Algeria | 2002 | 3.2 |
| 2 | Bahrain | 2004 | 0.9 |
| 3 | Djibouti | 2007 | 1.5 |
| 4 | Egypt, Arab Rep. | 2004 | 4.1 |
| 5 | Iran, Islamic Rep. | 2000 | 1.1 |
| 6 | Iraq | 2009 | 3.9 |
| 7 | Jordan | 2005 | 2.0 |
| 8 | Kuwait | 2007 | 2.7 |
| 9 | Lebanon | 2003 | 2.1 |
| 10 | Libya | 2001 | 2.1 |

| | | | |
|---|---|---|---|
| 11 | Malta | 2010 | 9.0 |
| 12 | Morocco | 2003 | 1.9 |
| 13 | Oman | - | - |
| 14 | Qatar | - | - |
| 15 | Saudi Arabia | - | - |
| 16 | Syrian Arab Republic | 2004 | 1.3 |
| 17 | Tunisia | 2003 | 4.3 |
| 18 | United Arab Emirates | - | - |
| 19 | West Bank and Gaza | 2009 | 4.0 |
| 20 | Yemen, Rep. | 2004 | 1.5 |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

***Өмнөд Азийн орнуудын тэтгэврийн зардал ДНБ-д эзлэх хувиар*** *(Pension spending, South Asia region)*

Өмнөд Азийн 8 орны Тэтгэврийн зардал бүс нутгийн түвшинд Энэтхэг, Шри-Ланкын ДНБ-ий 2-оос илүү хувийг хамгийн их, бүс нутгийн бусад нь 1-ээс бага хувьтай байна.

**Хүснэгт 5.**

| *№* | *Орон* | *Тэтгэврийн зардал* | |
|---|---|---|---|
| | | *Огноо* | *ДНБ-д эзлэх хувь (GDP%)* |
| 1 | Afghanistan | 2005 | 0.5 |
| 2 | Bangladesh | 2006 | 0.3 |
| 3 | Bhutan | 2008 | 0.0 |
| 4 | India | 2007 | 2.2 |
| 5 | Maldives | 2006 | 0.2 |
| 6 | Nepal | 2006 | 0.2 |
| 7 | Pakistan | 2004 | 0.5 |
| 8 | Sri Lanka Bhutan | 2007 | 2.0 |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

**Сахарын Африкийн бүс нутгийн орнуудын тэтгэврийн зардал ДНБ-д эзлэх хувиар** *(Pension spending, selected countries Sub-Saharan Africa region)*

*Бүс нутгийн 47 орны тэтгэврийн зардлын ДНБ-нд эзлэх дундаж үзүүлэлт 1 хувь, 11 орон 1-ээс дээш хувийг тэтгэврийн зардалд зарцуулдаг байна. (Хүснэгт 5,6-аас үзнэ үү.)*

**Хүснэгт 6.**

| *№* | **Орон** | **Тэтгэврийн зардал** | |
|---|---|---|---|
| | | **Огноо** | **ДНБ *(GDP%)*** |
| 1 | Angola | - | - |
| 2 | Benin | 2006 | 1.5 |
| 3 | Botswana | 2009 | 1.3 |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Burkina Faso | 2004 | 0.7 |
| 5 | Burundi | 2006 | 0.7 |
| 6 | Cameroon | 2005 | 0.4 |
| 7 | Cape Verde | - | - |
| 8 | Central African Republic | 2004 | 0.8 |
| 9 | Chad | - | - |
| 10 | Comoros | - | - |
| 11 | Congo, Dem. Rep | - | - |
| 12 | Congo, Rep. | - | - |
| 13 | Cote d'Ivoire | 2006 | 0.7 |
| 14 | Equatorial Guinea | - | - |
| 15 | Eritrea | 2001 | 0.3 |
| 16 | Ethiopia | 2006 | 0.3 |
| 17 | Gabon | - | - |
| 18 | Gambia, The | 2003 | 0.1 |
| 19 | Ghana | 2002 | 1.3 |
| 20 | Guinea | - | - |
| 21 | Guinea-Bissau | 2005 | 2.1 |
| 22 | Kenya | 2003 | 1.1 |
| 23 | Lesotho | - | - |
| 24 | Liberia | - | - |
| 25 | Madagascar | - | - |
| 26 | Malawi | - | - |
| 27 | Mali | 2010 | 1.6 |
| 28 | Mauritania | 2003 | 0.6 |
| 29 | Mauritius | 2007 | 2.9 |
| 30 | Mozambique | 2006 | 0.3 |
| 31 | Namibia | 2004 | 1.3 |
| 32 | Niger | 2006 | 0.7 |
| 33 | Nigeria | 2004 | 0.9 |
| 34 | Rwanda | 2005 | 0.7 |
| 35 | Sao Tome and Principe | - | - |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

**Хүснэгт 7.**

| *№* | *Орон* | *Тэтгэврийн зардал* | |
|---|---|---|---|
| | | *Огноо* | *ДНБ-д эзлэх хувь (GDP%)* |
| 1 | Senegal | 2006 | 1.4 |
| 2 | Seychelles | 2006 | 2.9 |
| 3 | Sierra Leone | - | - |
| 4 | Somalia | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | South Africa | 2010 | 2.2 |
| 6 | Sudan | - | - |
| 7 | Swaziland | - | - |
| 8 | Tanzania | 2006 | 0.9 |
| 9 | Togo | 2003 | 0.8 |
| 10 | Uganda | 2003 | 0.3 |
| 11 | Zambia | 2008 | 1.4 |
| 12 | Zimbabwe | 2002 | 2.3 |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

***Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Холбооны Байгууллагуудын орнуудын тэтгэврийн зардал ДНБ-д эзлэх хувиар*** *(Pension spending, High-OECD countries)*

***ЭЗХАХБ-ын нийт 24 орноос Итали, Австрали Португал***,Грек, Герман ***ДНБ-ний*** 10-14.1 хувийг эзэлж байгаа нь бүс нутгийн төдийгүй дэлхийд ДНБ-д тэтгэврийн зардлыг эзлэх үзүүлэлтээр тэргүүлж байна.

**Хүснэгт 8.**

| *№* | *Орон* | *Тэтгэврийн зардал* | |
|---|---|---|---|
| | | *Огноо* | *ДНБ-д эзлэх хувь (GDP%)* |
| 1 | Australia | 2007 | 3.4 |
| 2 | Austria | 2007 | 12.3 |
| 3 | Belgium | 2007 | 8.9 |
| 4 | Canada | 2007 | 4.2 |
| 5 | Denmark | 2007 | 5.6 |
| 6 | Finland | 2007 | 8.3 |
| 7 | France | 2007 | 12.5 |
| 8 | Germany | 2007 | 10.7 |
| 9 | Greece | 2010 | 13.5 |
| 10 | Ireland | 2007 | 3.6 |
| 11 | Israel | 2007 | 4.8 |
| 12 | Italy | 2007 | 14.1 |
| 13 | Japan | 2007 | 8.8 |
| 14 | Luxembourg | 2007 | 6.5 |
| 15 | Netherlands | 2007 | 4.7 |
| 16 | New Zealand | 2007 | 4.3 |
| 17 | Norway | 2007 | 4.7 |
| 18 | Portugal | 2007 | 10.8 |
| 19 | Spain | 2007 | 8.0 |
| 20 | Sweden | 2007 | 7.2 |
| 21 | Switzerland | 2007 | 6.4 |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | United Kingdom | 2007 | 5.4 |
| 23 | United States | 2007 | 6.0 |
| 24 | Iceland | 2007 | 1.9 |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

### *Гурав. Монгол Улсын нийгмийн хамгааллын зардлын төсөвт эзлэх хувь, хэмжээ*

Монгол Улсын нийгэм хамгааллын зардлын төсөвт эзлэх хувь, хэмжээ 1995, 2000, 2005, 2010, 2012 онуудад тасралтгүй бөгөөд хурдацтай өссөн байдалтай байна. Үүнийг хүснэгт болон графикаар харуулбал:

**Хүснэгт 1. (сая төгрөгөөр)**

| | *1995* | *2000* | *2005* | *2010* | *2012* |
|---|---|---|---|---|---|
| Төсвийн нийт зардал | 149349,8 | 372532,7 | 764597,1 | 3080685,1 | 6017800.5 |
| Нийгэм хамгааллын зардал | 19839,7 | 80537,9 | 183981,2 | 850334,4 | 1918067.3 |
| Нийгэм хамгааллын зардал төсөвт эзлэх хувь | 13.3% | 21.6% | 24.1% | 27.6% | 31.9% |

*Эх сурвалж: Холбогдох тоон мэдээллийг 1995, 2000, 2005, 2010, 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын нэгтгэсэн тайлангаас авав.*[106]

**Зураг 1.**

**1995 онд** нийгмийн даатгалын байгууллагаас тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын хуулиас гадна олгосон хөрөнгийг “халамжийн сан“-д төвлөрүүлж, олон хүүхэдтэй эхийн болон нярай хүүхэдтэй эхийн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, жирэмсэн болон амаржсан эхийн тэтгэмж, асрамжийн газар, хүүхдийн асаргаа, сувилгааны зардал зэрэг нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст чиглэсэн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үзүүлсэн байна.

Хөдөлмөрийн биржид бүртгэлтэй ажилгүй хүмүүс, 18-аас доош насны хүүхэд, нийгмийн даатгалаас тэтгэвэр, тэтгэмж авагсад, асрамжийн газар амьдардаг хүмүүсийн тоо нийт хүн амын 80 хувь байгаа нь төсвийн зардалд жинтэй нөлөө үзүүлжээ.

[106]Монгол Улсын 1995 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн тайлан,
Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн тайлан,
Монгол Улсын 2005 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайлан,
Монгол Улсын 2010 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын нэгтгэсэн тайлан,
Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын нэгтгэсэн тайлан.

**2000 онд** нийгэм хамгааллын зардал өсөхөд:

- нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо өссөн
- дундаж тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн
- Нийгмийн халамжийн сангаас жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авдаг эхийн тоо өссөн нь тус тус нөлөөлжээ.

**2005 онд** нийгмийн хамгааллын зардал өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлжээ:

- 2005 оны 4-р сарын 1-нээс тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэхээр төсөвт тусгасан боловч тэтгэвэр тогтоолгох итгэлцүүрийг 2005 оны 2-р сарын 1-нээс шинэчлэн тогтоосон, тэтгэвэр авагчдын тоо нэмэгдсэн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж 12 сараас дээш хугацаагаар шимтгэл төлж ажилласан тэтгэвэр авагчдын тэтгэвэр нэмэгдсэн зэргээс хамаарч өндөр настны тэтгэврийн зардал, тахир дутуу бологсдын тэтгэврийн зардал өссөн.
- тэтгэвэрт болон группэд байгаа хүмүүс ажил эрхэлж байгаад халагдсан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж олгох болсон
- ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авагчдын тоо, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авагчдын тоо нэмэгдсэнээс эдгээр тэтгэмжийн хэмжээ тус тус нэмэгдсэн.
- халамжаас олгогддог өндөр настан, ахмад дайчдад олгох хөнгөлөлт, тахир дутуу хүмүүст олгох хөнгөлөлт, халамжийн тэтгэвэр, халамжийн бусад хөнгөлөлт үйлчилгээний зардлууд өссөн ба халамжийн тэтгэвэр, тэтгэмжид төлөвлөснөөс илүү олон хүн хамрагдсан байна.

Хамгийн гол нь 2005 онд Монгол Улсын төсөв анх удаа ашигтай гарч, хүүхэд, гэр бүлийн хөгжилд зориулагдах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгосон. Ингэснээр Хүүхдийн мөнгөн тэтгэмж, шинээр төрсөн хүүхдэд нэг удаа мөнгөн тусламж, шинээр гэр бүл бологсдод нэг удаа мөнгөн тусламж зэрэг улс төрийн намуудын сонгуулийн амлалтыг биелүүлэх зорилгоор нийгмийн халамжид зориулах хөрөнгийн хэмжээг өсгөжээ.

**2010 онд** нийгэм хамгааллын зардлын өсөлтөд:

- Халамжийн сангаас эх хүүхдэд олох тэтгэмж болон хүүхэд, эх, гэр бүлд олгох мөнгөн тусламж тэтгэмжид хамрагдах иргэдийн тоо нэмэгдсэн.
- Нийгмийн халамжийн шинэчлэлийн нэг хэсэг болох Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо өссөн.
- Хүний хөгжил сангаас 2.6 сая иргэнд 277.1 тэрбум төгрөгийн хувь хишиг хүртээсэн нь нөлөөлжээ.

**2012 онд** дараах үзүүлэлтүүд нийгэм хамгааллын зардлыг өсгөхөд голлон нөлөөлсөн байна:

- бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 35.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 180.3 мянган төгрөг болсон, өндөр насны дундаж тэтгэвэр 222.6 мянган төгрөг хүрсэн зэргээс шалтгаалж тэтгэврийн даатгалын сангийн зарлага нэмэгдсэн.
- хүний хөгжил сангаас оюутны сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, бэлэн мөнгөөр хишиг, хувь хүртээх, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон 1 сая төгрөг, сар бүр олгох 21 мянган төгрөг, 0-18 насны хүүхдэд сар бүр 20 мянган төгрөг олгох ажлууд Хүний хөгжил сангийн санхүүжилтээр хийгдэж байгаа нь нийгэм хамгааллын зардалд даацтай нөлөөлсөн байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- 1.I nternational Patterns of Pension Provision II “Social protection&labor“ 2012-http://www-wds.worldbank.org/servlet/WDSContentServer/WDSP/IB/2012/06/21/000333038_20120621024626/Rendered/PDF/703190NWP0SPL000Box370035B00PUBLIC0.pdf-
- «О негосударственных пенсионных фондах» (№75-ФЗ от 7.05.1998)
- “Об инвестировании средств для финансирования накопительной части трудовой пенсии в Российской Федерации”2002 N 111-ФЗ
- Inheriting a SERPS pension, SERPSL1, December 2007;
- www.is4profit.com/pdf/pm2sep06.pdf - United Kingdom
- SERPS and the State Second Pension and in the following leaflets
- http://www.legislation.gov.uk/


**Хавсралт 1.**

**Зүүн Ази, Номхон далайн орнуудын тулгууруудын загварчлал**
(Modality of pillars by country, East Asia & Pacific)

| *№* | *Орон* | *Тулгуурын загварчлал* | | |
|---|---|---|---|---|
| | | *0 тулгуур* | *1-р тулгуур* | *2-р тулгуур* |
| 1 | Brunei Darussalam | U | PF | - |
| 2 | Cambodia | .. | .. | .. |
| 3 | China | T | DB | - |
| 4 | Fiji | T | PF | - |
| 5 | Hong Kong SAR, China | U | - | DC |
| 6 | Indonesia | - | PF | - |
| 7 | Kiribati | - | PF | - |
| 8 | Korea, Rep. | B | DB | - |
| 9 | Lao PDR | - | DB | - |
| 10 | Malaysia | T | PF | - |
| 11 | Marshall Islands | .. | .. | - |
| 12 | Micronesia, Fed. Sts. | - | DB | - |
| 13 | Mongolia | U | NDC | - |
| 14 | Palau | - | DB | - |
| 15 | Papua New Guinea | - | PF | - |
| 16 | Philippines | B | DB | - |
| 17 | Samoa | B | PF | - |
| 18 | Singapore | - | PF | - |
| 19 | Solomon Islands | - | PF | - |
| 20 | Thailand | - | DB | - |
| 21 | Timor-Leste | U | - | - |
| 22 | Tonga | .. | .. | .. |
| 23 | Vanuatu | - | PF | - |
| 24 | Vietnam | T | DB | - |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

Тайлбар: олдоогүй: ..
хэрэглэдэггүй: -
0 тулгуур:
1.T /targeted programms/- төлөвлөсөн хөтөлбөрүүдтэй
2. B /basic pensions/- үндсэн тэтгэврүүдтэй-
3. U /universal/- нийтлэг
1-р тулгуур: улсын албан журмын зохицуулалтын схем
1. DB /defined benefit/- хуваарилалтын схем
2. NDC /notional defined contribution/- нэрийн дансны схем
3. PF /Provident Funds/ -Хяналтын сангууд
2-р тулгуур: хувийн менежменттэй албан журмын хуримтлалын схем
1. DC /defined contibution/- хуримтлалын схем
2. DB /defined benefit/- хуваарилалтын схем

**Хавсралт 2.**

**Европ болон Төв Азийн орнуудын тулгууруудын загварчлал**
(Modality of pillars by country, Europe & Central Asia region)

| *№* | *Орон* | *Тулгуурын загварчлал* | | |
|---|---|---|---|---|
| | | *0 тулгуур* | *1-р тулгуур* | *2-р тулгуур* |
| 1 | Albania | T | DB | - |
| 2 | Armenia | T | DB | - |
| 3 | Azerbaijan | T | DB, NDC | - |
| 4 | Belarus | - | DB | - |
| 5 | Bosnia and Herzegovina | - | DB | - |
| 6 | Bosnia Republika Srpska | - | DB | - |
| 7 | Bulgaria | T | DB | DC |
| 8 | Croatia | - | DB | DC |
| 9 | Czech Republic | B | DB | - |
| 10 | Estonia | B | DB | DC |
| 11 | Georgia | T | DB | - |
| 12 | Hungary | - | DB | DC |
| 13 | Kazakhstan | U | DB | DC |
| 14 | Kosovo | U | - | DC |
| 15 | Kyrgyz Republic | B | DB, NDC | DC |
| 16 | Latvia | T | NDC | DC |
| 17 | Lithuania | B | DB | DC |
| 18 | Macedonia, FYR | - | DB | DC |
| 19 | Moldova | - | DB | - |
| 20 | Montenegro | - | DB | - |
| 21 | Poland | - | DB, NDC | DC |
| 22 | Romania | - | DB | DC |
| 23 | Russian Federation | T | NDC | DC |
| 24 | Serbia | - | DB | - |
| 25 | Slovak Republic | - | DB | DC |
| 26 | Slovenia | T | DB | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 27 | Tajikistan | - | DB | DC |
| 28 | Turkey | - | DB | - |
| 29 | Turkmenistan | T | DB | - |
| 30 | Ukraine | T | DB | - |
| 31 | Uzbekistan | T | DB | - |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

**Хавсралт 3.**

**Латин Америк, Карибын орнуудын тулгууруудын загварчлал**
(Modality of pillars by country, Latin America & the Caribian region)

| *№* | *Орон* | *Тулгуурын загварчлал* | | |
|---|---|---|---|---|
| | | *0 тулгуур* | *1-р тулгуур* | *2-р тулгуур* |
| 1 | Antigua and Barbuda | T | DB | - |
| 2 | Argentina | T,B | DB | - |
| 3 | Barbados | T | DB | - |
| 4 | Belize | T | DB | - |
| 5 | Bolivia | U | DB | - |
| 6 | Brazil | T | DB | - |
| 7 | Chile | T | - | DC |
| 8 | Colombia | T | DB | DC OP |
| 9 | Costa Rica | T | DB | DC Co |
| 10 | Cuba | T | DB | - |
| 11 | Dominica | - | DB | - |
| 12 | Dominican Republic | T | - | DC |
| 13 | Ecuador | T | DB | - |
| 14 | El Salvador | - | DB PO | DC Op |
| 15 | Grenada | - | DB | - |
| 16 | Guyana | - | DB | - |
| 17 | Haiti | - | DB | - |
| 18 | Honduras | - | DB | - |
| 19 | Jamaica | - | DB | - |
| 20 | Mexico | T | DB | DC Op |
| 21 | Nicaragua | B | DB PO | - |
| 22 | Panama | T | DB | DC Co |
| 23 | Paraguay | - | DB | - |
| 24 | Peru | - | DB | DC OP |
| 25 | St. Kitts and Nevis | - | DB | - |
| 26 | St. Lucia | T | DB | - |
| 27 | St. Vincent and the Grenadines | - | DB | - |
| 28 | Suriname | - | DB | .. |
| 29 | Trinidad and Tobago | .. | .. | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 30 | Uruguay | T | DB | DC |
| 31 | Venezuela, RB | T | DB | - |
| 32 | Guatemala | - | DB | - |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*
*Тайлбар: Co (Complementary scheme) - нэмэлт схем*
*Op (Optional) - албан журмын*

**Хавсралт 4.**

**Дундад Ази болон Өмнөд Африкийн орнуудын тулгууруудын загварчлал**
(Modality of pillars by country, Middle East & North Africa region)

| *№* | *Орон* | *Тулгуурын загварчлал* | | |
|---|---|---|---|---|
| | | *0 тулгуур* | *1-р тулгуур* | *2-р тулгуур* |
| 1 | Algeria | - | DB | - |
| 2 | Bahrain | - | DB | - |
| 3 | Djibouti | - | DB | - |
| 4 | Egypt, Arab Rep. | U | DB 1 | - |
| 5 | Iran, Islamic Rep. | - | DB | - |
| 6 | Iraq | - | DB | - |
| 7 | Jordan | - | DB | - |
| 8 | Kuwait | - | DB | - |
| 9 | Lebanon | .. | .. 2 | .. |
| 10 | Libya | - | DB | - |
| 11 | Malta | T | DB | - |
| 12 | Morocco | - | DB | - |
| 13 | Oman | - | DB | - |
| 14 | Qatar | .. | .. | .. |
| 15 | Saudi Arabia | - | DB | - |
| 16 | Syrian Arab Republic | - | DB | - |
| 17 | Tunisia | - | DB | - |
| 18 | United Arab Emirates | - | DB | - |
| 19 | West Bank and Gaza | .. | .. | .. |
| 20 | Yemen, Rep. | - | DB | - |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

**Хавсралт 5.**

**Өмнөд Азийн орнуудын тулгууруудын загварчлал**
(Modality of pillars by country, South Asia region)

| *№* | *Орон* | *Тулгуурын загварчлал* | | |
|---|---|---|---|---|
| | | *0 тулгуур* | *1-р тулгуур* | *2-р тулгуур* |
| 1 | Afghanistan | .. | .. | .. |
| 2 | Bangladesh | T | - | - |
| 3 | Bhutan | .. | .. | .. |
| 4 | India | T | DB, PF | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Maldives | U | - | DC |
| 6 | Nepal | T | PF | - |
| 7 | Pakistan | - | DB | - |
| 8 | Sri Lanka Bhutan | - | PF | - |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

**Хавсралт 6.**

**Сахарын Африкийн бүс нутгийн орнуудын тулгууруудын загварчлал**
(Modality of pillars by country, Sub-Saharan Africa region)

| *№* | *Орон* | *Тулгуурын загварчлал* | | |
|---|---|---|---|---|
| | | *0 тулгуур* | *1-р тулгуур* | *2-р тулгуур* |
| 1 | Angola | .. | .. | .. |
| 2 | Benin | - | DB | - |
| 3 | Botswana | U | DB | - |
| 4 | Burkina Faso | - | DB | - |
| 5 | Burundi | - | DB | - |
| 6 | Cameroon | - | DB | - |
| 7 | Cape Verde | - | DB | - |
| 8 | Central African Republic | - | DB | - |
| 9 | Chad | - | DB | - |
| 10 | Comoros | .. | .. | .. |
| 11 | Congo, Dem. Rep | - | DB | - |
| 12 | Congo, Rep. | - | DB | - |
| 13 | Cote d'Ivoire | - | DB | - |
| 14 | Equatorial Guinea | - | DB | - |
| 15 | Eritrea | .. | .. | .. |
| 16 | Ethiopia | .. | .. | .. |
| 17 | Gabon | - | DB | - |
| 18 | Gambia, The | - | PF | - |
| 19 | Ghana | - | DB | - |
| 20 | Guinea | - | DB | - |
| 21 | Guinea-Bissau | .. | .. | .. |
| 22 | Kenya | - | PF | - |
| 23 | Lesotho | B | - | - |
| 24 | Liberia | T | DB | - |
| 25 | Madagascar | - | DB | - |
| 26 | Malawi | .. | .. | .. |
| 27 | Mali | - | DB | - |
| 28 | Mauritania | - | DB | - |
| 29 | Mauritius | U | DB | - |
| 30 | Mozambique | .. | .. | .. |
| 31 | Namibia | U | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 32 | Niger | - | DB | - |
| 33 | Nigeria | - | - | - |
| 34 | Rwanda | - | DB | - |
| 35 | Sao Tome and Principe | - | DB | - |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

**Хавсралт 7.**

**(Үргэлжлэл)**

| № | Орон | Тулгуурын загварчлал | | |
|---|---|---|---|---|
| | | 0 тулгуур | 1-р тулгуур | 2-р тулгуур |
| 1 | Senegal | - | DB | - |
| 2 | Seychelles | B | DB | - |
| 3 | Sierra Leone | - | DB | - |
| 4 | Somalia | .. | .. | .. |
| 5 | South Africa | T | - | - |
| 6 | Sudan | - | DB | - |
| 7 | Swaziland | T | PF | - |
| 8 | Tanzania | - | DB | - |
| 9 | Togo | - | DB | - |
| 10 | Uganda | - | PF | - |
| 11 | Zambia | - | DB | - |
| 12 | Zimbabwe | - | *DB* | - |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

**Хавсралт 8.**

**Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Холбооны Байгууллагуудын орнуудын тулгууруудын загварчлал** (Modality of pillars by country, High-OECD countries)

| № | Орон | Тулгуурын загварчлал | | |
|---|---|---|---|---|
| | | 0 тулгуур | 1-р тулгуур | 2-р тулгуур |
| 1 | Australia | T | - | |
| 2 | Austria | - | DB | |
| 3 | Belgium | T m | DB | |
| 4 | Canada | T,B | DB | |
| 5 | Denmark | T,B | - | |
| 6 | Finland | - m | DB | |
| 7 | France | - m | DB | |
| 8 | Germany | T | DB | |
| 9 | Greece | - m | DB | |
| 10 | Ireland | B | - | |
| 11 | Israel | T | DB | |
| 12 | Italy | - | NDC | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 13 | Japan | B | DB | |
| 14 | Luxembourg | T,B m | DB | |
| 15 | Netherlands | B | - | |
| 16 | New Zealand | U | - | |
| 17 | Norway | - | DB | |
| 18 | Portugal | - m | DB | |
| 19 | Spain | - m | DB | |
| 20 | Sweden | - m | NDC | |
| 21 | Switzerland | T m | DB | |
| 22 | United Kingdom | T,B m | DB | |
| 23 | United States | T | DB | |
| 24 | Iceland | T,B | - | |

*Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан*

* * *